



МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ТОГТООЛ

2020 оны 4 сарын 14 өдөр

Дугаар 22

Улаанбаатар хот

Хяналтын тооллого хийх
журам батлах тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 71.18, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.18 дахь хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Сонгуулийн Ерөнхий Хорооноос ТОГТООХ нь:

1. "Хяналтын тооллого хийх журам"-ыг 1 дүгээр хавсралтаар, "Хяналтын тооллогын хуудас"-ны маягыг 2 дугаар хавсралтаар, "Хяналтын тооллогын дүнгийн нэгтгэл"-ийн маягыг 3 дугаар хавсралтаар, "Хяналтын тооллого хийсэн тухай тэмдэглэл"-ийн загварыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү журмыг хэрэгжүүлж ажиллахыг Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороод болон хяналтын тооллого хийгдэх хэсгийн хорооны дарга, гишүүдэд, биелэлтэд нь хяналт тавьж ажиллахыг Хорооны нарийн бичгийн дарга /Ц.Болдсайхан/-д тус тус даалгасугай.

3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны 2016 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн "Техникийн тооллого хийх журам батлах тухай" 172 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Ч. Содномцэрэн

Ч.СОДНОМЦЭРЭН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Ц. Болдсайхан

Ц.БОЛДСАЙХАН

000047

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны
2020 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн
22 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ХЯНАЛТЫН ТООЛЛОГО ХИЙХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Хяналтын тооллого хийх сонгуулийн хэсгийг сонгох, хяналтын тооллого хийх үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2.Хяналтын тооллого хийх үйл ажиллагаанд сонгуулийн тухай хууль тогтоомж болон энэ журмыг дагаж мөрдөнө.

1.3.Хяналтын тооллого хийх хэсгийг сонгох болон хяналтын тооллого хийх үйл ажиллагаанд сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигчийн ажиглагчдыг оролцуулна. Гадаадын ажиглагчид, сонгогчид, хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийг ажиглагчаар оролцуулж болно.

Хоёр. Хяналтын тооллого хийгдэх хэсгийг сонгох

2.1.Сум, дүүргийн сонгуулийн хороо нь санал хураалтын цаг дуусмагц хяналтын тооллого явуулах хэсгийг сонгохдоо санамсаргүй сонголт /сугалах/-ын аргыг хэрэглэнэ.

2.2.Хяналтын тооллогыг сум, дүүргийн сонгуулийн хороодын харьяалах нийт хэсгийн 50 хүртэл хувьд нь явуулна.

2.3.Сум, дүүргийн сонгуулийн хороо хяналтын тооллого хийх хэсгийг сонгохдоо харъяа бүх хэсгийн дугаар тус бүрийг тэмдэглэсэн сугалааг бэлтгэж, ажиглагчдад нэг бүрчлэн танилцуулж, тусгайлан бэлтгэсэн хайрцагт хийнэ.

2.4.Нам, эвсэл, нэр дэвшигчдийн 2 хүртэл төлөөллийг оролцуулан сугалаа хийж хяналтын тооллого хийх хэсгийг сонгоно.

2.5.Сум, дүүргийн сонгуулийн хороо хяналтын тооллого хийгдэхээр сонгогдсон хэсгийн хороонд нэн даруй мэдэгдэнэ.

2.6.Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухайд 100 хувь хяналтын тооллого хийх бөгөөд хяналтын тооллого хийгдэх сонгох зохицуулалт хамаарахгүй.

/Энэ хэсгийг Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны 28 дугаар тогтоолоор нэмсэн./

Гурав. Хяналтын тооллого хийх

3.1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.5.2-т заасны дагуу хийгдсэн тооцоог ажиглагч болон бусад оролцогчид мэдээлэл хийсний дараа хяналтын тооллогыг нэн даруй эхлүүлж, завсарлагагүйгээр явуулж дуусгана.

/Энэ хэсгийг Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны 28 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан./

3.2.Хэсгийн хорооны даргын даалгаснаар аль нэг гишүүн хяналтын тооллого хийсэн тухай тэмдэглэл хөтөлнө.

3.3.Хяналтын тооллогыг дараах дарааллын дагуу тасралтгүй, ил тод, нээлттэй зохион байгуулна:

3.3.1.хяналтын тооллогыг эхлүүлэхээс өмнө санал авах ажиллагаанд ашигласан санал тэмдэглэх зориулалт бүхий үзгийг бүрэн хураан авч, хайрцагт хийж битүүмжлэн лацадна;

3.3.2.хэсгийн хорооны гишүүд саналын хайрцагаас саналын хуудсыг гаргаж, 25 ширхэг тус бүрээр нь тоолж багцална;

3.3.3.багц тус бүрийг дугаарлах бөгөөд тухайн багц дахь саналын хуудсыг мөн дугаарлана. Багцын дугаар болон саналын хуудасны дугаарыг нэг дор тэмдэглэнэ. /1-1, 1-2, ... 1-25; 2-1, 2-2, ... 2-25 гэх мэт/;

3.3.4.хэсгийн хорооны дарга саналын хайрцагаас гарсан нийт саналын хуудас /багцалсан/-ны тоо нь тухайн санал авах байранд санал өгсөн сонгогчийн тоотой тохирч буй эсэхийг мэдээлнэ;

3.3.5.хэсгийн хорооны дарга багцалсан саналын хуудсыг дугаарласан дарааллын дагуу саналын хуудас нэг бүрийг дугаарын дарааллаар тоолон саналын хуудаст хийсэн тэмдэглэгээг ажиглагчдад ил тод /дүрс бичлэг, телевиз, эсхүл дэлгэц, проектор ашиглаж болно/-оор харуулан, нэр дэвшигч нэг бүрийн авсан санал тус бүрийг уншиж танилцуулна;

3.3.6.хэсгийн хорооны дарга саналын хуудсыг уншиж танилцуулахдаа нэр дэвшигч бүрийн авсан саналыг унших бөгөөд хэсгийн хорооны даргын томилсон гишүүн хяналтын тооллогын хуудаст нэр дэвшигчдийн авсан саналыг тус тусад нь тухай бүрт нь тэмдэглэнэ;

3.3.7.нэр дэвшигчид өгсөн саналыг тоолохдоо саналын хуудас тус бүрээр нь тоолж, улмаар багц тус бүрээр дүнг нэгтгэн гаргах бөгөөд тухай бүрт нь хяналтын тооллогын дүнгийн нэгтгэлд бүртгэнэ;

3.3.8.саналын хуудсыг тоолж дууссаны дараа хяналтын тооллогын нэгдсэн дүнг гаргаж, энэ тухай хэсгийн хорооны дарга мэдээлэл хийнэ.

3.4.Тэмдэглэлд хэсгийн хорооны бүрэлдэхүүн гарын үсэг зурна. Хяналтын тооллогын үйл ажиллагаанд оролцсон ажиглагчдаар тэмдэглэлд гарын үсэг зуруулж болно.

3.5.Санал тоолох төхөөрөмжөөс гарсан санал хураалтын дүнг тэмдэглэлд хавсаргана.

3.6.Хэсгийн хорооны дарга хяналтын тооллого хийсэн дүнг сум, дүүргийн сонгуулийн хороонд нэн даруй мэдээлэх бөгөөд сум, дүүргийн сонгуулийн хороод нь дүнг нэгтгэж, аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд, аймаг, нийслэлийн сонгуулийн хороод нь дүнг нэгтгэж, Сонгуулийн ерөнхий хороонд тус тус нэн даруй мэдээлнэ.

3.7.Хэсгийн хороо нь хяналтын тооллого хийсэн тухай тэмдэглэл, бусад холбогдох баримт бичгийг сум, дүүргийн сонгуулийн хороонд, сум, дүүргийн сонгуулийн хороо нь аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд, аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь Сонгуулийн ерөнхий хороонд тус тус хүлээлгэн өгнө.

3.8.Хяналтын тооллого хийсэн дүн, санал тоолох төхөөрөмжөөр гарсан дүн зөрсөн тохиолдолд энэ журамд заасан дарааллын дагуу дахин тоолж энэ тухай тэмдэглэлд тусгаж, дээд шатны сонгуулийн хороонд бусад баримтын хамт хүргүүлнэ.

/Энэ хэсгийг Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны 28 дугаар тогтоолоор нэмсэн./

3.9.Хяналтын тооллогын ажиллагааг зохион байгуулагчид буюу хэсгийн хорооны гишүүд нэг удаагийн зориулалт бүхий бээлий¹, богино ханцуйтай цамц өмссөн байна. Хяналтын тооллого хийх хугацаанд гартаа бугуйвч, бөгж, зүүлт, цаг зэрэг эд зүйл хэрэглэхийг хориглоно.

/Энэ хэсгийг Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны 28 дугаар тогтоолоор нэмсэн./

3.10.Хяналтын тооллогын үйл ажиллагааг бүхэлд нь хяналтын камерт буулгаж баталгаажуулна.

/Энэ хэсгийг Сонгуулийн ерөнхий хорооны 2021 оны 28 дугаар тогтоолоор нэмсэн./

Дөрөв. Хариуцлага

4.1.Сонгуулийн тухай хууль тогтоомж, энэ журамд заасныг зөрчсөн этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

---oOo---

¹Нэг удаагийн тунгалаг нитрил бээлий

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны
2020 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн
22 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

..... аймаг, дүүргийн дугаар хэсгийн хорооны хяналтын тооллогын хуудас

Багц №
Хуудас № ...

20... оны ... дугаар сарын ... өдөр

Нэр дэвшигчийн нэр	Саналын хуудасны тоо																									<u>Дүн</u>	
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	25		
1	А																										
2	Б																										
3	В																										
4	Г																										
5	Д																										
6	Е																										
7	Ж																										
8	З																										
9	И																										
10	К																										
11																										
<u>Саналын хуудаст тэмдэглэгдсэн нийт саналын тоо</u>																											

- Тайлбар:** 1. Нэг нүдэнд зөвхөн нэг саналыг гэж тэмдэглэнэ.
2. Нэр дэвшигчдийн авсан хүчинтэй саналын “**Дүн**”-ийн нийлбэр нь “**Саналын хуудас дээрх нийт саналын тоо**”-ны нийлбэртэй тэнцүү байх бөгөөд зөрсөн тохиолдолд тухайн багц дахь нийт 25 саналын хуудсыг дахин нягтлан шалгана.

Хяналтын тооллогын хуудаст тэмдэглэл хийж дүнг гаргасан гишүүн /...../

Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны
 2020 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн
 22 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

..... аймаг, дүүргийн дугаар хэсгийн хорооны хяналтын
 тооллогын дүнгийн нэгтгэл

	Нэр дэвшигчийн нэр	Хяналтын тооллогын багцийн дугаар																				Дүн
		1	2	3	4	5	6	7	8	9	...											
1	А																					
2	Б																					
3	В																					
4	Г																					
5	Д																					
6	Е																					
7	Ж																					
8	З																					
9	И																					
10	К																					
11	Л																					
12	М																					
13	Н																					
14	О																					
15	П																					
16																					
17																					
18																					
19																					
20																					

Тайлбар: Хөндлөн нүд болгонд нэр дэвшигч бүрийн авсан саналын тоог багц тус бүрээр бичнэ.

Хэсгийн хорооны дарга
 Гишүүд:

/...../
 /...../
 /...../

..... АЙМАГ, ДҮҮРГИЙН ДУГААР ХЭСГИЙН ХОРООНД
ХЯНАЛТЫН ТООЛЛОГО ХИЙСЭН ТЭМДЭГЛЭЛ

..... оны дугаар
сарын -ны өдөр

Дугаар

1.....
сонгуулийн санал авах ажиллагаа цагт дууссаны дараа хяналтын тооллого
хийгдэхээр сонгогдсон тул тус хэсгийн санал авах байранд хяналтын тооллогыг
цаг минутад эхлэв.

2.Хяналтын тооллогын ажиллагааг хэсгийн хорооны дарга
..... удирдаж, гишүүн,,
....., мэдээллийн
технологийн даамал нар оролцож гүйцэтгэв.

3.Нам, эвсэл, нэр дэвшигчдийн ажиглагчид болон сонгогчдын төлөөлөл:

1.
2.
3.
4. нар оролцов.

4.Хэсгийн хорооны бүрэлдэхүүн болон ажиглагчдын хяналтан дор, мэдээллийн
технологийн даамал ... хэсгийн хорооны санал авах байранд ашигласан санал тоолох
төхөөрөмжийн лацыг хөндөж, саналын хайрцагнаас санал тоолох төхөөрөмжийг
салгаж авав.

5.Саналын хайрцагнаас гаргаж авсан саналын хуудсуудыг тоолж, 25 ширхэгээр
багцлан дугаарласан бөгөөд нийт багц, ширхэг саналын хуудас байв.

6.Хэсгийн хорооны дарга саналын хайрцагнаас гарсан нийт саналын хуудасны
тоо, санал өгсөн сонгогчийн тоотой тохирч байгаа эсэхийг танилцуулав.

7.- хэсгийн хорооны санал авах байранд санал өгсөн сонгогчдийн тоо
.....

- Санал тоолох төхөөрөмжөөс гарсан саналын хуудасны тоо

8.Санал өгсөн сонгогчдын тоо нь саналын хайрцагнаас гарсан саналын
хуудасны тоотой тохирч буй эсэх

9.Хэсгийн хорооны дарга нь саналын хуудас тус бүрт
тэмдэглэсэн санал бүрийг нэр дэвшигч тус бүрээр уншиж, ажиглагчдад ил тод /видео
камер, телевиз эсхүл дэлгэц, проектор/-оор харуулсан ба хяналтын тооллогын
хуудасны тэмдэглэгээг хэсгийн хорооны гишүүн,

.....,,,
.....,,, тухай бүрт нь
тэмдэглэв.

10.Хяналтын тооллого дууссаны дараа нэгдсэн дүнг гаргаж нийтэд танилцуулав.

11.Хяналтын тооллогоор нэр дэвшигч:

1. /..... санал/
2. /..... санал/
3. /..... санал/
4. /..... санал/
5. /..... санал/
6. ...

12.Хяналтын тооллогыг ил тод, тасралтгүй явуулж, өдрийн цаг
..... минутад дуусгаж, мэдээлэв.

13.Саналын хуудсыг битүүмжлэх уутанд хийж сонгуулийн бусад баримт бичгийн хамт сум, дүүргийн сонгуулийн хороонд хүргүүлэхээр болов.

14. Санал тоолох төхөөрөмжөөс гарсан санал хураалтын дүнг хавсаргав.

Хяналтын тооллого хийсэн:

Хэсгийн хорооны дарга /

Гишүүд: / /
Тэмдэг / /
/ /
/ /
/ /
/ /
/ /
/ /
/ /